

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА

Огноо: 2021.05.03

Төсөл сонгон шалгаруулалтын нэр: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээг гэрээний үндсэн дээр зохион байгуулах мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах

Төсөл сонгон шалгаруулалтын дугаар: ХБХХЕГ/20210503/

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээний хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, ажилд дадлагжуулах, ажлын байрны орчинд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны онцлог хэрэгцээнд нь нийцсэн хэрэгцээт тохируулагыг хийх мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулалтад төслийн баримт бичиг ирүүлэхийг урьж байна.

Төслийн баримт бичгийн иж бүрдлийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 мянган төгрөгөөр худалдаж авна. Төслийн баримт бичгийг худалдаж авснаар төсөл сонгон шалгаруулалтад оролцох эрх үүснэ.

Төслийн баримт бичгийг 2021 оны 06 сарын 04-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлэх бөгөөд 2021 оны 06 сарын 04-ны өдрийн 11.00 цагт нээнэ. Нээлтэд оролцох хүсэлтэй төслийн баримт бичгийг ирүүлсэн оролцогчдыг байлцуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 3 давхрын хурлын зааланд нээнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дор дурдсан хаягаар авна уу.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Бодлогын хэрэгжилтийн газар 122 тоот,

Холбоо барих утас: 77073000, 95009671